



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ГАДААД СЕКТОРЫН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны жилийн гүйцэтгэл

Улаанбаатар
2020




1. Төлбөрийн тэнцэл

Урсгал ба хөрөнгийн данс 2019 онд 2,001 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 2,678 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 453 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -224 сая ам.доллар байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 114 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 587 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 4,349 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 9.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)




Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 6%-аар өсч 13,208 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 1,158 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 288 сая ам.доллараар (10%), мөнгөжөөгүй алт 274 сая ам.доллараар (190%), төмрийн хүдэр 234 сая ам.доллараар (68%) тус тус өссөн бол СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 264 сая ам.доллараар (11%), нефтийн бүтээгдэхүүний импорт 53 сая ам.доллараар (5%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцэлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 355 сая ам.доллараар өсчээ.


Дүрслэл 2. Барааны худалдаа (сая ам.доллар)



Үйлчилгээний худалдаа


2019 онд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 1%-иар буюу 13 сая ам.доллараар өсч, 1,992 сая ам.долларт хүрсэн.

Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа (сая ам.доллар)




Үйлчилгээний экспорт өмнөх оноос 11%-иар буюу 121 сая ам.доллараар өсч 1,233 сая ам.долларт хүрчээ. Үүний 42% буюу 513 сая ам.долларыг аялал жуулчлал, 32% буюу 389 сая ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээний экспортын орлого бүрдүүлж байна.

Дүрслэл 4. Үйлчилгээний экспорт (сая ам.доллар)



Өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад үйлчилгээний импорт 4%-иар буюу 135 сая ам.доллараар өсч, 3,224 сая ам.долларт хүрсэн ба үүнээс 30%-ийг буюу 983 сая ам.долларыг тээвэр, 29%-ийг буюу 213 сая ам.долларыг аялал жуулчлал, 24%-ийг буюу 772 сая ам.долларыг бусад, 7%-ийг буюу 212 сая ам.долларыг санхүүгийн үйлчилгээ авахад тус тус зарцуулжээ.

Дүрслэл 5. Үйлчилгээний импорт (сая ам.доллар)




Аялал жуулчлалын үйлчилгээ

Сүүлийн 3 жилийн дунджаар аялал жуулчлалын үйлчилгээний дансны орлого нь манай улсын нийт үйлчилгээний экспортын 39%-ийг, зарлага нь нийт үйлчилгээний импортын 28%-ийг бүрдүүлсэн байна.


Тэгвэл аялал жуулчлалын үйлчилгээний салбарын орлогын 21%-ийг БНСУ, 19%-ийг БНХАУ, 12%-ийг ОХУ, 5%-ийг Япон, 33%-ийг бусад улсын аялагчдад үзүүлсэн үйлчилгээнээс хүлээн авсан байна.

Дүрслэл 6. Аялалын үйлчилгээний экспорт, 2017-2019 (сая ам.доллар)



Харин аялал жуулчлалын салбарын импортыг улсаар нь ангилбал: Монгол улсын иргэд нийт зардлын 20%-ийг Япон, 17%-ийг БНСУ, 8%-ийг ОХУ, 8%-ийг Герман, 5%-ийг БНХАУ-д аялахдаа зарцуулсан байна.


Дүрслэл 7. Аялалын үйлчилгээний импорт, 2017-2019 (сая ам.доллар)



Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 1,569 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оноос 28%-иар буюу 341 сая ам.доллараар өссөн үзүүлэлтэй байна. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал голчлон нөлөөлсөн. Тайлант жилд манай улс гадаад бонд, үнэт цаасны хүүгийн төлбөрт 397 сая ам.доллар, ногдол ашигт 216 сая ам.доллар, шууд хөрөнгө оруулагчийн зээлийн хүүгийн төлбөрт 481 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 507 сая ам.доллар, харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт 99 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Дүрслэл 8. Анхдагч орлого (сая ам.доллар)



Хоёрдогч орлого

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2019 онд Монгол улс нийт 241 сая ам.доллараар бага орлого хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 6%-иар буурсан, харин гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 5%-иар өссөн байна цэвэр дүнгээр 131 сая ам.долларын орлого авсан.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оноос 57 сая ам.доллараар буурсан байна.

Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2019 (мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Дүн	Хувь	Өсөлт	Дүн	Хувь	Өсөлт
Солонгос	120,400	47% ▲	10%	15,861	13% ▲	117%
Америк	17,824	7% ▼	-40%	16,892	14% ▲	48%
Хятад	1,615	1% ▼	-67%	3,944	3% ▼	-60%
Гонг Конг	3,116	1% ▲	14%	1,184	1% ▲	35%
Англи	10,910	4% ▼	-8%	6,809	6% ▲	125%
ОХУ	41,534	16% ▲	2393%	10,778	9% ▲	16%
Сингапур	4,477	2% ▲	77%	4,144	3% ▲	97%
Швейцарь	5,474	2% ▲	7%	497	0% ▲	15%
Герман	7,975	3% ▲	58%	3,065	2% ▲	21%
Япон	3,333	1% ▼	-3%	3,033	2% ▲	19%
Бусад	37,611	15% ▲	10%	56,813	46% ▲	111%
НИЙТ	254,269	100%		123,021	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2019 онд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 3,131 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 687 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 2,443 сая ам.долларын орох урсгалтай байв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 402 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь харвал:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оноос 239 сая ам.доллараар өсч, 1,887 сая ам.доллар,
- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 101 сая ам.доллараар өсч, 156 сая ам.доллар, харин
- Япон улсаас ирсэн хөрөнгө оруулалт 122 сая ам.доллараар буурч, 122 сая

ам.доллар,

- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 43 сая ам.доллараар буурч, 315 сая ам.долларын орох урсгалтай байсан байна.

Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	2019		2019/2018	
		Дүн	Хувь	Өөрчлөлт	
1	Австрали	20	1%	4	▲
2	АНУ	88	3%	10	▲
3	Англи	75	2%	55	▲
4	БНХАУ	315	10%	-43	▼
5	Герман	13	0%	9	▲
6	Нидерланд	6	0%	2	▲
7	Хонг-Конг	170	5%	91	▲
8	Канад	1,887	60%	239	▲
9	Люксембург	128	4%	63	▲
10	ОХУ	31	1%	13	▲
11	Сингапур	156	5%	101	▲
12	Солонгос (өмнөд)	22	1%	-5	▼
13	Турк	1	0%	1	▲
14	Франц	13	0%	-2	▼
15	Япон	122	4%	-122	▼
16	Бусад	86	3%	-16	▼
	Нийт	3,131	100%	402	▲

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагааны салбар 118 сая ам.доллараар,
- Уул уурхайн салбар 244 сая ам.доллараар,
- Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 43 сая ам.доллараар тус тус өссөн бол,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 43 сая ам.доллараар,
- Боловсруулах үйлдвэрлэлийн салбар 17 сая ам.доллараар,
- Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар 5 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	2018	2019	2019/18	
				Өөрчлөлт	
1	Барилга	22	53	31	▲
2	Боловсрол	1	2	1	▲
3	Боловсруулах үйлдвэрлэл	43	27	-17	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	143	261	118	▲
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	10	14	3	▲
6	Мэдээлэл, холбоо	8	6	-1	▼
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	17	17	0	▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	224	192	-32	▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2	29	28	▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл	25	67	43	▲
11	Уул уурхай, олборлолт	2130	2374	244	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	64	68	3	▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	21	16	-5	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан	3	3	0	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	1	-1	▼
16	Бусад	15	1	-14	▼
	Нийт	2729	3131	402	▲


Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2019 онд 372 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх онтой харьцуулахад ашиг 311 сая ам.доллараар өссөн байна.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- МИК 300 сая ам.долларын бонд гаргасан,
- Энержи Ресус ХХК 440 сая ам.долларын бонд гаргаж, өмнө гаргасан бондынхоо төлбөрт 398 сая ам.долларыг төлсөн байна.

Дүрслэл 9. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)




Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд өмнөх санхүүгийн дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд, үүнд, арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүд, худалдааны зээллэг зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

2019 онд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 5 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал, 114 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Энэ өөрчлөлтөд хувийн салбарын гадаад зээлийн үндсэн төлбөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 10. Бусад хөрөнгө оруулалт



2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2019 оны эцэст 35,831 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна. Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 7,140 сая ам.доллар байна. Үүний 61%-ийг гадаад валютын албан нөөц, 26%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 42,971 сая ам.долларт хүрчээ. Үүний 52%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 35%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц 2018 оны жилийн эцсийн дүнгээс 7%-иар буюу 2,202 сая ам.доллараар өссөн байна.

Үүнийг ерөнхий бүтцээр авч үзвэл: гадаад актив 16%-иар буюу 984 сая ам.доллараар, гадаад пассив 8%-иар буюу 3,185 сая ам.доллараар тус тус өссөн.


Харин дансаар нь авч үзвэл: гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,201 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 557 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 253 сая ам.доллар, албан нөөц 800 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Позит (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2018	12/31/2019	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позит	-33,630	-35,831	2,202	7%
I. Гадаад актив	6,156	7,140	984	16%
1. Шууд хөрөнгө оруулалт	533	665	132	25%
2. Багцын хөрөнгө оруулалт	297	284	-13	-5%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	09	09	1435x
4. Бусад хөрөнгө оруулалт	1,784	1,841	57	3%
5. Нөөц актив	3,542	4,341	800	23%
II. Гадаад пассив	39,786	42,971	3,185	8%
1. Шууд хөрөнгө оруулалт	20,223	22,556	2,333	12%
2. Багцын хөрөнгө оруулалт	4,887	5,430	544	11%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	01	00	-01	-100%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,675	14,985	310	2%

Позицийн нийт өөрчлөлтийг авч үзвэл: төлбөрийн тэнцлийн урсгалаар -2,225 сая ам.доллар, ханшийн өөрчлөлтөөр 236 сая ам.доллар, бусад өөрчлөлтөөр -33 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр -180 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Дүрслэл 11. Гадаад актив, пассив (сая ам.доллар)



Шууд хөрөнгө оруулалт


Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 12,189 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 10,366 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 7,805 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 35%,
- БНХАУ-аас 5,069 сая ам.доллар буюу 22%,
- Сингапур улсаас 1,478 сая ам.доллар буюу 7%,

- Люксембург улсаас 1,477 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 7%-ийг тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 12. Шууд шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, 2019




Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2019 онд 284 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 5%-иар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 5,430 сая ам.долларт хүрч, 11%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Актив: манай эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл: Хонг-Конг 31%, АНУ 12%, Сингапур 12%, Австрали 8%, Канад 8%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Монголын эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал: АНУ 21%, Их Британ 9%, Люксембург 5%, Сингапур 3%, Герман 2%, үлдсэн 41% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 13. Багцын ХО-ын үлдэгдэл, 2019 (сая ам.доллар)



3. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны эцэст 30,702 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 7-иар буюу 1,987 сая ам.доллараар нэмэгдлээ.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 622 сая ам.доллараар өсч 7,806 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 46 сая ам.доллараар буурч, 1,985 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,411 сая ам.доллараар өсч 20,911 сая ам.долларт хүрээд байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар).

Үзүүлэлт	12/31/2018	12/31/2019	Өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	28,715	30,702	1,987	7%	100%
I. Засгийн газар	7,184	7,806	622	9%	25%
Бонд, өрийн бичиг	2,946	3,123	177	6%	
Зээл	4,238	4,683	445	10%	
II. Төв банк	2,030	1,985	-46	-2%	6%
III. Банк	2,230	2,138	-92	-4%	7%
Богино хугацаат	764	610	-154	-20%	2%
Урт хугацаат	1,466	1,528	62	4%	5%
IV. Бусад сектор	8,042	8,407	365	5%	27%
Богино хугацаат	609	562	-47	-8%	2%
Урт хугацаат	7,433	7,845	412	6%	26%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,228	10,366	1,138	12%	34%

*: Нийт өсөлтөөд оруулсан хувь


Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2019 оны эцэст 2,138 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 92 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 43%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 13%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 919 сая ам.доллар, 288 сая ам.долларт хүрэв.

Дүрслэл 14. Банкны салбарын гадаад өр (сая ам.доллар)



Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2019 оны эцэст 18,773 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,503 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.


Салбарын нийт зээлийн 55% буюу 10,334 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс

ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа, төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 317 сая ам.доллар болсон байна.

Дүрслэл 15. Бусад салбарын гадаад өр (сая ам.доллар)



Мэдээллийн эх сурвалж:

Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс

Монголбанк: ТТБГазар, ССГазар

Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл

Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	Он			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2017	2018	2019	Дүн	2018/17	Дүн	2019/18
I. УРСГАЛ ДАНС	-1,155	-2,207	-2,162	-1,051	-91%	45	2%
Барaa ба үйлчилгээний худалдаа	278	-1,303	-834	-1,580	-569%	469	36%
Кредит	6,801	7,668	8,416	868	13%	747	10%
Дeбeт	6,523	8,971	9,249	2,448	38%	278	3%
1. Барaa	1,494	676	1,158	-818	-55%	483	71%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	5,834	6,557	7,183	722	12%	626	10%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	4,341	5,881	6,025	1,540	35%	144	2%
2. Үйлчилгээ	-1,216	-1,978	-1,992	-762	-63%	-13	-1%
Кредит	966	1,112	1,233	145	15%	121	11%
Дeбeт	2,182	3,090	3,224	907	42%	135	4%
2.1 Тээвэр	-284	-561	-594	-277	-98%	-34	-6%
Кредит	320	354	389	34	11%	35	10%
Дeбeт	604	915	983	311	52%	69	7%
2.2 Аялал	-137	-415	-412	-278	-203%	3	1%
Кредит	396	445	513	50	13%	68	15%
Дeбeт	533	860	925	327	61%	65	8%
2.3 Бусад үйлчилгээ	-795	-1,003	-986	-207	-26%	17	2%
Кредит	251	312	330	62	25%	18	6%
Дeбeт	1,046	1,315	1,316	269	26%	1	0%
3 Анхдагч орлого	-1,613	-1,228	-1,569	385	24%	-341	-28%
Кредит	76	346	394	269	352%	49	14%
Дeбeт	1,689	1,573	1,963	-116	-7%	390	25%
3.1 Ажилчдын цалин	-44	185	196	229	520%	12	6%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-1,574	-1,425	-1,792	149	9%	-367	-26%
3.3 Бусад	6	13	27	8	132%	14	107%
4 Хоёрдогч орлого	180	324	241	144	80%	-83	-26%
Кредит	264	448	374	184	69%	-73	-16%
Дeбeт	85	124	134	40	47%	9	8%
Үүнээс: Хувийн гуйвуулга	20	122	82	102	505%	-40	-33%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	78	92	161	14	18%	69	75%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дeбeт	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	78	92	161	14	18%	69	75%
Кредит	82	93	162	12	14%	69	74%
Дeбeт	4	2	1	-3	-62%	0	-11%
<u>Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)</u>	<u>-1,078</u>	<u>-2,115</u>	<u>-2,001</u>	<u>-1,037</u>	<u>-96%</u>	<u>114</u>	<u>5%</u>
III. САНХҮҮГИЙН ДАНС	-2,599	-2,091	-2,678	508	20%	-587	-28%
<u>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)</u>	<u>-2,599</u>	<u>-2,091</u>	<u>-2,678</u>	<u>508</u>	<u>20%</u>	<u>-587</u>	<u>-28%</u>
1. Шууд хөрөнгө оруулалт	-1,446	-2,137	-2,316	-691	-48%	-180	-8%
1.1 Актив	49	37	127	-12	-24%	90	243%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	49	38	85	-10	-21%	47	123%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	-1	42	-1		43	3782%
1.2 Пассив	1,494	2,174	2,443	679	45%	270	12%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	828	1,000	1,231	173	21%	231	23%
1.2.2 Өрийн хэрэгсэл	666	1,173	1,212	507	76%	39	3%
2. Багцын хөрөнгө оруулалт	-493	-61	-372	432	88%	-311	-512%
2.1 Актив	-27	47	15	73	276%	-32	-68%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-30	54	5	84	278%	-48	-90%
2.1.2 Өрийн бичиг	4	-7	9	-11	-293%	16	235%
2.2 Пассив	467	107	387	-359	-77%	280	260%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-10	-7	7	3	32%	14	207%
2.2.2 Өрийн бичиг	477	114	380	-362	-76%	265	232%
3. Санхүүгийн үүсгэл хэргсэлүүд	17	-13	6	-30	-176%	19	146%
3.1 Актив	0	-12	5	-12	-2876%	18	142%
3.2 Пассив	-17	0	-1	18	102%	-1	-310%
4. Бусад хөрөнгө оруулалт	-677	119	5	797	118%	-114	-96%
4.1 Актив	-349	-110	44	239	68%	154	140%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	-346	-22	38	324	94%	61	270%
4.1.3 Зээл	-4	-38	-12	-34	-901%	26	67%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	1	-50	18	-51	-3930%	68	136%
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	329	-229	39	-558	-170%	268	117%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	143	-33	-52	-176	-123%	-19	-56%
4.2.3 Зээл	222	-142	156	-365	-164%	298	210%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	-264	-86	-116	178	67%	-30	-35%
4.2.3.3.1 Богино хугацаат	-110	49	3	159	145%	-46	-94%
4.2.3.3.2 Урт хугацаат	-154	-135	-119	18	12%	16	12%
4.2.3.2 Засгийн газар	848	487	462	-360	-43%	-25	-5%
4.2.3.4 Бусад салбар	-362	-543	-190	-182	-50%	353	65%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-42	-54	-65	-11	-27%	-11	-21%
4.2.6 Бусад авлага	6	0	0	-6	-100%	0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
IV. Алдаа болон орхигдуулга	-62	-118	-224	-56	-1	-106	-1
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	1,460	-142	453	-1,602	-110%	595	420%
1. ГВУН	1,577	-38	453	-1,616		491	
2. ОУВС-гийн зээл	117	104	0	-14		-104	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2018	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(33,630)	(34,384)	(34,501)	(34,795)	(35,831)
Актив	6,156	6,541	6,874	6,964	7,140
Шууд хөрөнгө оруулалт	533	546	565	584	665
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	466	478	497	515	556
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	466	478	497	515	556
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	67	68	69	68	109
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	66	68	68	68	108
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	297	286	288	286	284
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	279	269	262	262	255
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	23	22	23	22	22
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	256	247	240	240	233
Бусад санхүүгийн байгууллага	210	211	214	216	218
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	46	36	26	25	15
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0
Өрийн бичиг	18	18	25	24	29
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	7	7	9	6	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	10	10	16	17	23
Бусад санхүүгийн байгууллага	0	10	10	10	10
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	6	7	7
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	0	3	6	5	9
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	0	0	0	1
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	3	5	4	9
Бусад санхүүгийн байгууллагууд	0	3	5	4	9
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	1,784	2,052	1,921	2,112	1,841
Бусад хөрөнгө	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,283	1,520	1,402	1,541	1,324
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	461	808	665	873	582
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	822	712	737	668	742
Бусад санхүүгийн байгууллага	0	0	13	27	2
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	822	712	724	641	740
Зээл	150	156	156	156	145
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	150	156	156	156	145
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	(0)	0	0	0	0
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	352	376	364	416	372
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0
Ноц хөрөнгө	3,542	3,653	4,094	3,978	4,341

Үзүүлэлт	12/31/2018	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019
Гадаад пассив	39,786	40,925	41,375	41,759	42,971
Шууд хөрөнгө оруулалт	20,223	20,674	21,230	21,687	22,556
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	10,995	11,304	11,583	11,864	12,189
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	10,995	11,304	11,583	11,864	12,189
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
Өрийн хэргсэл	9,228	9,370	9,647	9,822	10,366
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	9,228	9,370	9,647	9,822	10,366
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
Багийн хөрөнгө оруулалт	4,887	5,392	5,431	5,412	5,430
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	75	74	77	78	79
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	21	21	20	20	20
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	54	53	57	58	59
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0
Өрийн бичиг	4,811	5,318	5,354	5,334	5,351
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	624	631	622	627	609
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	2,946	3,117	3,107	3,095	3,123
Бусад салбарууд	1,241	1,569	1,625	1,612	1,619
Бусад санхүүгийн байгууллага	787	1,124	1,122	1,121	1,116
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	451	443	59	52	61
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	1	0	0	0	0
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	14,675	14,858	14,714	14,660	14,985
Бусад хөрөнгө	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	2,123	2,194	2,081	2,012	2,039
Төв банк	1,745	1,786	1,747	1,683	1,717
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	327	397	334	329	322
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	51	11	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	51	11	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Зээл	12,265	12,404	12,341	12,375	12,629
Төв банк	286	287	286	265	268
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,279	1,352	1,274	1,250	1,207
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	4,238	4,307	4,341	4,335	4,683
Бусад салбарууд	6,462	6,459	6,439	6,526	6,471
Бусад санхүүгийн байгууллага	292	300	322	415	428
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	6,170	6,159	6,117	6,111	6,042
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	288	260	292	273	318
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2016	12/31/2017	12/31/2018	3/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019
Засгийн газар	4,869	7,321	7,184	7,424	7,448	7,430	7,806
Богино хугацаат	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	4,869	7,321	7,184	7,424	7,448	7,430	7,806
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,064	3,549	2,946	3,117	3,107	3,095	3,123
Зээл	2,805	3,772	4,238	4,307	4,341	4,335	4,683
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Төвбанк	1,791	2,025	2,030	2,072	2,034	1,948	1,985
Богино хугацаат	1,725	1,837	1,745	1,786	1,747	1,683	1,717
Харилцах, хадгаламж 5/	1,725	1,837	1,745	1,786	1,747	1,683	1,717
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	65	188	286	287	286	265	268
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	65	188	286	287	286	265	268
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,417	2,194	2,230	2,380	2,230	2,205	2,138
Богино хугацаат	469	659	764	776	717	677	610
Харилцах, хадгаламж 5/	-	314	327	397	334	329	322
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-
Зээл	469	345	437	378	383	348	288
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	1,948	1,535	1,466	1,605	1,513	1,529	1,528
Харилцах, хадгаламж 5/	240	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	611	589	624	631	622	627	609
Зээл	1,098	946	842	973	891	902	919
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Бусад салбарууд	8,121	7,956	8,042	8,299	8,356	8,411	8,407
Богино хугацаат	394	666	609	522	559	521	562
Харилцах, хадгаламж 5/	-	95	51	11	-	-	-
Өрийн бичиг 4/	2	2	2	2	2	2	2
Зээл	218	292	275	269	285	266	262
Худалдааны зээл болон урьдчилгаа	175	277	281	240	272	253	298
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	7,727	7,289	7,433	7,778	7,797	7,890	7,845
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	884	726	1,239	1,567	1,623	1,610	1,617
Зээл	6,802	6,560	6,187	6,190	6,154	6,260	6,208
Худалдааны зээл болон урьдчилгаа	41	3	7	20	20	20	20
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	7,426	7,996	9,228	9,370	9,647	9,822	10,366
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	7,426	7,996	9,228	9,370	9,647	9,822	10,366
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-	-
Нийт гадаад өр	24,625	27,493	28,715	29,546	29,715	29,817	30,702